


СҮРЬЕЭГИЙН ТУХАЙ




1 Сүрьеэ гэж юу вэ?

- Сүрьеэ нь сүрьеэгийн нянгаар үүсдэг амьсгалын замын халдварт өвчин юм. Ихэвчлэн уушгийг гэмтээдэг ч бусад эрхтнийг мөн өвчлүүлж болно.



2 СҮРЬЕЭ ХЭРХЭН ХАЛДВАРЛАДАГ ВЭ?

- Уушгины сүрьеэтэй хүн ханиах, найтаах эсвэл ярих үед нян агаарт тархаж, бусдын уушгинд орсноор халдварлана.



АСУУЛТ БА ХАРИУЛТ(Q&A)

KOREA DISEASE CONTROL AND
PREVENTION AGENCY



Q1 СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ ХЭД ВЭ?

A1 Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүн

Эрүүл мэндийн даатгалтай хүн эмчилгээ дуусах хүртэл сүрьеэгийн эмчилгээний зардлаас бүрэн чөлөөлөгдөнө.

※Хоол болон даатгалд хамрагдаагүй зарим зардлыг өвчтөн төлж болно.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүн

Эрүүл мэндийн даатгалгүй хүн
Эмчилгээний зардлаа өөрөө төлнө. Харин эрүүл мэндийн төв эсвэл улсын сүрьеэгийн эмнэлэгт үнэ төлбөргүй эмчлүүлэх боломжтой.

※Хоол болон даатгалд хамрагдаагүй зарим зардлыг төлж болно.

※Богино хугацаагаар оршин суугч болон шаардлага хангаагүй MDR-TB өвчтөнд халдваргүй болох хүртэл төсвийн хүрээнд дэмжлэг үзүүлж болно.

УЛСЫН СҮРЬЕЭГИЙН ЭМНЭЛГҮҮД

Масан улсын сүрьеэгийн
эмнэлэг



215 Gapo-ro, Masanhappo-gu,
Changwon-si,
Gyeongsangnam-do

☎ 055-249-5051

Мокпо улсын
сүрьеэгийн эмнэлэг



75 Sinjima-eul 1-gil, Mokpo-si,
Jeollanam-do

☎ 061-280-1114

Q2 БИ ЭХ ОРОНДОО БУЦАЖ СҮРЬЕЭГЭЭ ЭМЧЛҮҮЛЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА. ДАРАА НЬ СОЛОНГОСТ ДАХИН ОРЖ БОЛОХ УУ?

A2 Болно. Эх орондоо буцсаны дараа эмчилгээгээ үргэлжлүүлнэ үү. Эмчилгээ дууссаныг баталгаажуулсны дараа Солонгост дахин орж болно.

※Оршин суугаа улс дахь БНСУ-ын Элчин сайдын яам эсвэл Консулын газраар дамжуулан баталгаажуулах бичиг баримт өгнө.

Q3 ЭМЧИЛГЭЭГ ДУРААРАА ЗОГСООХ ЭСВЭЛ ЗААВАР МӨРДӨХГҮЙ БОЛ ЯАХ ВЭ?

A3 Солонгост эмчилгээний зааврыг мөрдөхгүй эсвэл эмчилгээгээ зогсоовол тусгай хяналтад бүртгэгдэж болно. Эрүүл мэндийн төвөөс эмнэлэгт хэвтэхийг шаардаж болно. Улсаас гарсныг баталгаажуулбал дахин нэвтрэхийг хориглож болно.

※Гарсныг хилээр нэвтэрсэн бүртгэлээр баталгаажуулна.
※Оршин суугаа улсад эмчилгээгээ дуусгаж, БНСУ-ын Элчин сайдын яам эсвэл Консулын газраар баталгаажуулсан бичиг баримт өгвөл хоригийг цуцалж болно.

Гадаадын сүрьеэтэй өвчтөнд
зориулсан

сүрьеэ

Сүрьеэгийн эмчилгээ, хяналтын
заавар



Tuberculosis

질병관리청

결핵 ZER

인기있는
결핵
Management of TB Patients

Сүрьеэгийн шинжилгээ

KOREA DISEASE CONTROL AND
PREVENTION AGENCY



1 ГОЛ ШИНЖ ТЭМДЭГ



2 долоо хоногоос
дээш ханиалгах



Жин буурах



Халуурах



Шөнө хөлрөх



Ядарч сульдах



Хоолны
дуршил буурах

2 СҮРЬЕЭГ СЭЖИГЛЭВЭЛ ЯАХ ВЭ?

- Ойролцоо эрүүл мэндийн төв, эмнэлэг эсвэл клиникт сүрьеэгийн шинжилгээ өгнө үү.

СҮРЬЕЭГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

Эрүүл мэндийн төв



Үнэгүй

Эмнэлэг/клиник



Өөрөө төлнө

3 СҮРЬЕЭГИЙН ҮЕД ЯМАР ШИНЖИЛГЭЭ ХИЙДЭГ ВЭ?



1 ЦЭЭЖНИЙ РЕНТГЕН ШИНЖИЛГЭЭ

- Сүрьеэг илрүүлэх үндсэн шинжилгээ юм.
- Хариунд сүрьеэ сэжиглэгдсэн бол цэрний шинжилгээ нэмж хийнэ.



2 ЦЭРНИЙ ШИНЖИЛГЭЭ

- Цэрэнд сүрьеэгийн нян байгаа эсэхийг шалгана.
- Сүрьеэ оношлогдвол заавал эмчилгээ хийнэ.

Сүрьеэгийн эмчилгээ

KOREA DISEASE CONTROL AND
PREVENTION AGENCY



1 ЭМЭНД МЭДРЭГ СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭ

- Сүрьеэг 6 сар болон түүнээс дээш хугацаанд тогтмол эмчилбэл эдгэрэх боломжтой. Шинж тэмдэг намдлаа гээд эмээ зогсоох эсвэл эмнэлэгт очихгүй бол дахиж болно. Эрүүл мэндийн ажилтан эмчилгээ дууссаныг баталгаажуулах хүртэл эмчилгээгээ үргэлжлүүлнэ үү.

INH

Isoniazid

INH

Rifampicin

INH

Rifampicin

INH

Rifampicin

INH

Ethambutol

PZA

Pyrazinamide

BCMP

Tubis



ХАЛДВАРЫН ХЯНАЛТЫН ДЭГЛЭМ

- Агаар сэлгэлт сайтай тусгаар өрөөнд ганцаараа байна.
- Ханиах, найтаахдаа салфеткаар таглаж, тагтай хогийн саванд хаяна.
- Гадагш гарах болон эмнэлэгт очих бүрдээ амны хаалт зүүнэ.

2 ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭ

- MDR-TB-ийн эмчилгээ илүү урт (ихэвчлэн 6-20 сар), илүү төвөгтэй байдаг. Туршлагатай мэргэжлийн багийн хяналтад эмчлүүлэхийг зөвлөж байна.

MDR-TB ГЭЖ ЮУ ВЭ?

Сүрьеэгийн үндсэн эмүүд болох isoniazid болон rifampicin-д хоёуланд нь тэсвэртэй сүрьеэг хэлнэ.

MDR-TB ЯАГААД ҮҮСДЭГ ВЭ?

Анхнаасаа MDR-TB-ийн нянгаар халдварлах, эмийг зааврын дагуу уухгүй байх эсвэл эмчилгээг эрт зогсоох үед үүсч болно.

MDR-TB-ИЙН МЭРГЭШСЭН
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ

